



# “ЖУУЛЧИН ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ

2024 оны 03 сарын 15 өдөр

№ 02

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлыг зарлан хуралдуулах тухай.

- Компанийн 2024 оны 03 дугаар сарын 15- ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:
1. “Жуулчин говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 13:00 цагт “Монгол савхи” ХК-ийн хурлын танхимд хуралдуулсугай.
  2. Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.
    - Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан
    - Компанийн ТУЗ-ийн тайлан
    - Аудитын хорооны тайлан
    - ТУЗ-ийн гишүүдийг сонгох
  3. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсугай.
    - Комиссын дарга: Д.Сүрэнхорол
    - Комиссын гишүүд: Г.Хүрэлбаатар, Ц.Мөнхнасан
  4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Г.Мөнхбилэгийг томилсугай.
  5. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.
    - Комиссын дарга: Д.Сүрэнхорол
    - Комиссын гишүүд: Г.Хүрэлбаатар, Ц.Мөнхнасан
  6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар мэдээг хүргэх, хуралтай холбогдох асуудлыг зохих хууль, журмын дагуу эрхлэн чвуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
  7. Ээлжит хурлын зарыг олон нийтэд хүргэх өдрийг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөр, бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 05 -ны өдрөөр тус тус тогтоосугай.
  8. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь хавсралт 1-д заасан бичиг баримттай танилцах бүрэн эрхтэй болохыг дурьдсугай.
  9. Хувьцаа эзэмшигчдын ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны агуулгыг хавсралт 2-т зааснаар баталсугай.
  10. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 13:00 цагаар тасалбар болгосугай.

ТУЗ-ийн ДАРГА Г.МӨНХБИЛЭГ

